



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/513

Арвайхээр

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.5, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 4.7, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 07/05 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн худалдаа, үйлчилгээний цэгүүдэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тавигдах шаардлагыг хангасан Хужирт сумын иргэн Ц.Долгорын “Ундрэм” хүнсний дэлгүүрийн тусгай зөвшөөрлийн сунгалтыг 2 жилээр, Арвайхээр суманд шинээр нээгдсэн Номин Тав Трейд ХХК-ийн “Номин агуулах худалдаа Арвайхээр” салбарт тусгай зөвшөөрлийг шинээр 2 жилийн хугацаатай тус тус олгосугай.

2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий худалдааны газруудад хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа О.Ганбат)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100893